



**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН**

Тайланг үнэлсэн:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Аймгийн Засаг дарга
(албан тушаал)
Тэмдэг

_____ (Д.Мөнхбаатар)
(гарын үсэг)

_____ (огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Нэгжийн дарга

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ,
үнэлгээний хэлтсийн дарга
(албан тушаал)
Тэмдэг

_____ (Т.Хуягбаатар)
(гарын үсэг)

_____ (огноо)

Тайлагнасан:

Төсвийн Шууд Захирагч

Төв аймгийн Биеийн Тамир Спортын Газрын дарга
(албан тушаал)

_____ (Д.Алтанхуяг)
(гарын үсэг)

_____ (огноо)

**ТӨВ АЙМГИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО**

2022.12.12

Зуунмод

№	Зорилт, арга хэмжээ	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц					Оноо
			Үр дүнтэй 100%	Толорхой үр дүнд хүрсэн 70%	Толорхой үр дүн гарч эхэлсэн 30%	Үр дүнгүй 0%	Гүйцэтгэлийн хувь	
1.	Биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, биеийн тамир спортын хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.	10	9	1	-	-	97 %	48.5
2.	Их спортын төрлүүдийн сургалт дасгалжуулалт, тэмцээн наадмын тогтолцоог боловсронгуй болгож үндэсний спортын төрлүүдийг уламжлал, ёс жаягийн дагуу хөгжүүлэн өсвөр, залуучуудын тамирчдын амжилтыг ахиулан тив дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	10	10	-	-	100 %	5	
3.	Байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй хууль, дүрэм, журам, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамруулан албан хаагчдын нийгмийн баталгааг хангана	17	15	2	-	-	97.0 %	48.5
	Дундаж үнэлгээ	37	34	2	-	-	98.0	49

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:

(Х.ГОМБОСҮРЭН)

ХЯНАСАН. БТСГ-ЫН ДАРГА

(Д.АЛТАНХУЯГ)

**ТӨВ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН 2022 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл ийн хувь	Дээд шатны үнэлгээ
Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг болгон хөгжүүлнэ.								
1	Зорилт 1. Биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөнийг дэмжин иргэдэд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, биеийн тамир спортын хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх, төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан нээлттэй уян хатан тогтолцоог бүрдүүлнэ.	Улсын төсөв 30 000 0 сая төгрөг	Биеийн тамир, спортын үйлчилгээг хүн амд үзүүлэн, төр хувийн хэвшлийн түншлэлд суурилсан уян хатан тогтолцоог бүрдүүлэх	Иргэдэд Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх талаар бодлогын баримт бичиг, хэрэгжүүлэх арга хэмжээний нөхцөл бүрдсэн.	100 %	Биеийн тамир, их спортын 398 арга хэмжээнд 55218 иргэнийг хамруулж, Заамар суманд шинээр спортын заалыг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад оруулж стандарт хангасан заал талбай 38%-тай, БЖИ-ийн судалгаанд 28428 иргэнийг хамруулснаас 20986 иргэн ба 73.82% нь хэвийн жинтэй, сорил судалгаанд 45218 иргэнийг хамруулснаас 69.9%-нь зохих түвшинд хүрч, спортын 23 холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан 34.5 сая төгрөгийн дэмжлэг туслалцаа үзүүлэн хамтран ажиллаа.	97%	
2	Арга хэмжээ 1.1. Иргэдийг насны ангиллаар бие бялдрын түвшин тогтоох сорил судалгаанд хамруулна	Улсын төсөв 1 000 0 сая төгрөг	- Хамрагдсан хүний тоо -Сорилд хамрагдсан иргэдийн үнэлгээний үзүүлэлтийн эзлэх хувь	Иргэдийн 24.8 хувь буюу 20256 иргэн хамрагдаж 7862 иргэн буюу 32.8 хувь нь А, В, С үнэлгээ авсан	Иргэдийн 48.5 хувийг сорилд хамруулж А, В, С үнэлгээтэй иргэдийг 39.4 хувиар нэмэгдүүлнэ.	Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил судалгаанд 45218 хүн буюу хамрагдвал зохих иргэдийн 69.9 %-ийг хамруулсан. Үүнээс 17.892 иргэн буюу “А”, “В”, “С”-гийн эзлэх хувь нь 39.5% байна.	100%	
3	Арга хэмжээ 1.2. Иргэдийг хөдөлгөөний дутагдлаас сэргийлж, эрүүл амьдрах дадал олгох биеийн жингийн	Улсын төсөв 2 000 0 сая төгрөг	-Хамрагдсан хүний тоо	31.876 хүн ба хамрагдвал зохих иргэний	28352 хүнийг хамруулж Хэвийн жинтэй хүний эзлэх хувийг	2022 оны хувьд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлэгийн үзлэг оношилгоонд хамрагдсан иргэд, цэргийн насны залуучуудаас биеийн жингийн индексийн судалгааг 28428 иргэнээс	100%	

	индексийг тодорхойж хэвийн жинтэй иргэдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх			71.3 %-ийг хамруулсан.	73.8%-д хүргэнэ	авахад 20986 иргэн буюу 73.82% нь хэвийн жинтэй иргэд байна.		
4	Арга хэмжээ 1.3. Нийтийг хамарсан биеийн тамир, спортын үйл ажиллагааг өргөжүүлж иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ	Улсын төсөв 5 000 0 сая төгрөг	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо -Хамрагдсан иргэдийн эзлэх хувь	Аймгийн хэмжээнд 233 арга хэмжээнд иргэдийн 42.4 хувь буюу 23065 иргэнийг хамруулсан	391 арга хэмжээнд 54970 хүнийг хамруулан нийт хүн амын 48.5 %-ийг хамруулна.	Нийтийн биеийн тамир, их спорты 398 арга хэмжээнд 55.218 иргэнийг хамруулсан. Илүүдэл жингүй эртгэч Монгол аяныг 2022.02.16 наас 05-р сарын 27-ны өдрийг хүртэл улс орон даяар явуулах хугацаанд Төв аймаг 11 спорт заал, 4 фитнес танхим, 15 гадаа талбай, 7 иог бясалгал, 11 чийрэгжүүлэх танхимд иргэдийг дасгал хөдөлгөөнд хамруулахад алхалт, гүйлтээр 6365, иог бясалгалаар 1238, дугуйгаар 334, дасгал хөдөлгөөнөөр 27566, нийт 35.303 иргэн хамрагдсан амжилтаар МУ-ын ерөнхий сайдын нэрэмжит батламжаар шагнууллаа. Нийгмийн эрүүл мэндийн өдөр, нарны алхалтыг 2022.05.04-ны өдрөөс эхлэн бүх сумдад эхлүүлэх, сумдад алхалтын клуб байгуулах талаар Зуунмод алхалтын клубын тэргүүн 6-р багийн Засаг дарга Б.Отгонбаяр заавар зөвлөгөө өгч аймгийн хэмжээнд 22 сум, 7 байгууллагад 31 клуб, сонирхогчдын бүлэг байгуулагдан 913 иргэн тогтмол алхалт хийж байна.	100%	
5	Арга хэмжээ 1.4. Нийтийн биеийн тамир спортын үйл ажиллагааг иргэдэд хүргэх сум бүрийг биеийн тамирын арга зүйтэй болгох ажлыг үргэлжлүүлнэ	Орон нутгийн төсөв	-Арга зүйчтэй сумдын тоо	3 сум Арга зүйч ажиллсан	3 суманд арга зүйчтэй болно	НБТ, их спортын 398 арга хэмжээнд хамруулвал зохих иргэний 86%-ийг хамруулан Баянчандмань, Баянхангай, Алтанбулаг, Баянцогт, сумд орон тооны арга зүйчдийг нэмэлт санхүүжилтээс цалинжуулан ажиллуулж байна. Сумд өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан БТС-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтыг үндэслэн орон тооны арга	70%	

						зүйчийг ажиллуулах албан тоотыг Засаг даргын орлогч Н.Буманбуян даргаар батлуулан сумдад хүргүүлсэн.Сумдын нийгмийн бодлогын ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтод нийтийн биеийн тамир спортын ажлыг хариуцан хийх нэмэлт заалтыг оруулан давхар хариуцуулан ажиллуулж байна.		
6	Арга хэмжээ 1.5. Ахмадын хөдөлгөөн эрүүл мэнд өдөрлөгийг зохион байгуулж хамрагдах хүний тоог нэмэгдүүлнэ	Улсын төсөв 2 000 0 сая төгрөг	- Зохион байгуулсан тоо - Хамрагдсан хүний тоо	Ковид-19 цар тахлаас шалтгаалан зохион байгуулагдаагүй	3 бүсэд 468 ахмадыг хамруулна. Баян, Цээл Аргалант	Ахмадын хөдөлгөөн эрүүл мэнд өдөрлөгийг Аргалант, Цээл, Баян, Эрдэнэсант сумдад зохион байгуулан явуулж 655 ахмадыг хамруулж спортын 5 төрлийн арга хэмжээг зохион явууллаа.Мөн төвийн бүсийн ахмадуудын аварга шалгаруулах болон “Төв кап-22” граунд гольфийн нээлттэй тэмцээнүүдийг зохион байгуулж 169 ахмадуудыг хамруулсан. Алхалт, гүйлт, дугуйгаар тогтмол хичээллэдэг 500 гаруй ахмад байгааг судалгаанд хамруулсан.	100%	
7	Арга хэмжээ 1.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл бололцоог сайжруулах тэдний дунд зохиогдох спортын арга хэмжээг нэмэгдүүлнэ	Улсын төсөв 1 000 0 сая төгрөг	Хамрагдсан хүний тоо	Цар тахлаас шалтгаалан үйл ажиллагаа явагдаагүй	71 иргэнийг хамруулна.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд хөнгөн атлетик, шатар, даамын тэмцээнийг зохион явуулж 42 иргэнийг хамруулж.Монголын бүх ард түмний XV их наадмын сонсголын бэрхшээлтэй иргэдийн сагсан бөмбөг, пара хөнгөн атлетик, жү-до бөх, хонхот бөмбөгийн төрлөөр 21 тармирчин оролцуулсан	100%	
8	Арга хэмжээ 1.7. Иргэдэд үйлчлэх стандарт хангасан заал талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх олон улсын жишигт нийцүүлэн засвар үйлчилгээг шат дараатай хийж	Орон нутгийн төсөв 5 000 0 сая төгрөг	- Стандарт хангасан заал талбайн тоо	52 спорт заалны 36.5 % 30 сургуулийн гадаа талбайгаас 41.9 % нь шаардлага хангасан	Спорт заалны 37.1 %, гадаа талбайн 42.3 %-ийг шаардлага хангуулна.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 54 спортын заалнаас 21 спорт заал ба 41% нь стандарт хангаж, 29 гадаа талбайн 12 нь ба 42 % нь шаардлага хангасан, 2022 онд 60.0 сая төгрөгөөр гадаа талбайд засвар үйлчилгээ хийх ба шинээр барьж байгуулах ажил 11 суманд хийгдэхээр төсөв төлөвлөгөө нь батлагдан Заамар,	100%	

	тохижилтыг сайжруулна.					Архуст, Баянжаргалан, Батсүмбэр, Баянхангай, Зуунмод сумын Баянхошуу багт гадаа талбайн засвар үйлчилгээ хийгдэн шинээр байгуулагдсан.		
9	Арга хэмжээ 1.8. Биеийн тамир, спортын зарим чиг үүргийг гэрээний дагуу төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана	Улсын төсөв 5 000 0 сая төгрөг	Дэмжлэг үзүүлж хамтран ажилласан ТББ, спорт холбоод	Чөлөөт, жүдо бөх, дугуй цанын холбоо	6-8 ТББ, спорт холбоод	Орон нутагт үйл ажиллагаагаа явуулж буй спортын 22 холбоотой хамтран ажиллах гэрээ байгуулан спортын клубүүдийг байгуулж аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг холбоод бие даан явуулснаар холбоодын үйл ажиллагаа идэвхжин оролцох оролцоо нэмэгдсэн. Аймгийн хэмжээнд 22 спорт холбоо 18 спортын клуб үйл ажиллагаа явуулж байна. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үе, залуучууд, ахмад, насанд хүрэгчдийн ангиллаар спортын 23 төрлөөр зохион явуулан НБТ-ын арга хэмжээнд 48.066.300, их спортын арга хэмжээнд 96.419.400 төгрөгийг зарцуулан спорт холбоодтой хамтран ажилласан. Спорт холбоодын форумыг зохион байгуулж 19 холбооны тэргүүн нарийн бичгийн дарга нартай спортын төрлүүдийн хөгжлийн чиг хандлагыг ярилцаж санал хүсэлтийг сонслоо.	100%	
10	Арга хэмжээ 1.9. Биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах мэдээллийн технологийн бааз, бий болгож хэрэгжүүлнэ	Улсын төсөв 1 000 0 сая төгрөг	Цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо Цахим хуудсанд хандалтын тоо	71 контентыг байршуулж 84459 иргэн хандалт хийсэн	85 мэдээ мэдээллийг 90 мянган иргэнийг мэдээллээр хангана	Иргэдийн идэвхтэй дасгал хөдөлгөөнд уриалах, дасгал хөдөлгөөн хийх ач тусын талаар 128 контентуудыг цаасан болон, цахим хэлбэрээр өгч 92.684 иргэнийг мэдээ мэдээллээр ханган идэвхтэй хөдөлгөөнд уриалан хамтран ажилласан. Илүүдэл жингүй эртэч Монгол аянд нэгдэн 35.303 иргэний хамруулж дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлсэн. Тухай жилд цол зэргийн болзол хангасан, улс болон олон улсын тэмцээн уралдаанаас тамирчдын авсан	100%	

						медалын судалгаа зэргийн тусгай файл үүсгэн цахим архив болгон хадгалан мэдээллийн баазыг бий болгосон		
11	Арга хэмжээ 1.10. Иргэдийн спортын наадам биеийн тамирын арга хэмжээг зохион байгуулна.	Улсын төсөв 8 000 0 сая төгрөг	Спортын төрлийн тоо Хамрагдсан иргэдийн тоо	Спортын 3 төрлөөр 27 сумын 1264 иргэн оролцсон	Спортын 3 төрлөөр 27 сумын 2120 иргэн хамруулна	Зуунмод сумын Иргэдийн спортын анхдугаар наадмыг 2022.04.07-08-ны өдрүүдэд спортын 6-н төрлөөр зохион явуулж 6 багийн 612 тамирчин оролцуулж 1,2 сая төгрөг, "Атарчин-2022" спортын наадмын 2022.11.26-27-нд зохион байгуулж 23 сумын 351 тамирчин оролцуулж 7.2 сая төгрөг зарцуулсан	100%	
Стратеги төлөвлөгөөний зорилго 2. Их спортыг дэмжиж, үндэсний спортыг өв уламжлалын дагуу хөгжүүлж, төр хувийн хэвшлийн түншлэлд суурилан тамирчдын амжилтыг нэмэгдүүлнэ.								
12	Зорилт 2.1. Их спортын төрлүүдийн сургалт дасгалжуулалт, тэмцээн наадмын тогтолцоог боловсронгуй болгож үндэсний спортын төрлүүдийг уламжлал, ёс жаягийн дагуу хөгжүүлэн өсвөр, залуучуудын тамирчдын амжилтыг ахиулан тив дэлхийн түвшинд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	Улсын төсөв 90 000 0 сая төгрөг	- Спортын сургалт дасгалжуулалт, тэмцээн наадмын шаталсан тогтолцоо тамирчдын тив дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар нэмэгдэнэ	УАШТ-нд 6 төрлөөр оролцон 34 алт, 24 мөнгө, 26 хүрэл нийт 84 медаль хүртсэн	Тив, дэлхийн тэмцээнд спортын 3 төрлөөр 8-10 тамирчинг оролцуулна. МБАТ XV наадам, МҮС VII надамд оролцох	Тив дэлхий, олон улс, улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 13 төрлөөр 468 тамирчин оролцуулж өсвөрийн шигшээ багийг спортын 13 төрлөөр 160 тамирчинтай хичээллүүлж улс, бүс, олон улсын тэмцээнээс 193 алт, 191 мөнгө, 252 хүрэл нийт 636 медаль хүртэж спортын мастер 8, дэд мастер 3, нийт 237 тамирчин спортын цол зэрэг биелүүлсэн. Монголын бүх ард түмний XV их наадмыг аймгийн хэмжээнд спортын 12 төрлөөр зохион явуулж 2564 иргэнийг хамруулан шигшээ тэмцээнд 12 төрлөөр 158 тамирчин оролцуулж 1 алт, 2 мөнгө, 5 хүрэл нийт 8 медаль хүртэн 18-р байранд шалгарсан. Аймгийн үндэсний спортын VII их наадмыг мөсний сур, шагай, үндэсний сур, үндэсний бөх, морин спортын төрлүүдээр зохион явуулан 18 сумын 101 тамирчин хамрагдаж, VII их наадмын шигшээ тэмцээнд 63 тамирчинг оролцуулж 4 алт, 5 мөнгө, 5 хүрэл, нийт 14 медаль	100%	

						хүртэж спортын дэд мастер 2 шинээр төрөн гарсан. Сурагчдын 19 олимпийн наадамд, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд дугуй, чөлөөт бөх, масристинг, самбо бөх, жү-до бөх, жюү-жицү бөхийн төрлүүдээр оролцож 9 алт, 4 мөнгө, 8 хүрэл, нийт 21 медаль хүртсэн.		
13	Арга хэмжээ 2.1. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын тодорхой төрлүүдээр цахим болон бусад хэлбэрээр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмадын насны ангиллаар зохион явуулж хамрагдах хүний тоог нэмэгдүүлнэ	Улсын төсөв 10 000 0 сая төгрөг	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо - Хамрагдсан хүний тоо	6 төрлөөр 740 хүн хамрагдсан.	149 арга хэмжээнд 32541 хүнийг хамруулна	Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмад гэсэн насны ангилалаар спортын 23 төрлөөр 124 арга хэмжээг зохион явуулж 32541 иргэнийг хамруулсан.	100%	
14	Арга хэмжээ 2.2. Спортын секц дугуйланг хичээллүүлж сургалт дасгалжуулалтыг чанаржуулан тамирчдын амжилтыг ахиулна.	-	-Секц дугуйланд хамрагдсан хүний тоо	14 төрлөөр 6134	20 төрлөөр 10314 хүнийг хамруулна.	Спортын секц дугуйланг 21 төрлөөр хичээллүүлж 10.351 хүүхэд залуучуудыг хамруулж өсвөрийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтад 160 тамирчинг хамруулж олон улс, улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс 567 медаль хүртэж, сурагчдын олимпод 2, Азийн аварга шалгаруулах тэмцээнд 4, дэлхийн аваргын тэмцээнд 5 тамирчин амжилттай оролцлоо.	100%	
15	Арга хэмжээ 2.3. Спортын цол зэрэгтэй тамирчдыг нэмэгдүүлнэ.	-	-Цол зэрэгтэй тамирчдын тоо	153 зэрэгтэй тамирчид төрсөн	168 зэрэгтэй тамирчдыг төрүүлнэ.	Спортын 18 төрлөөр спортын мастер 8, спортын дэд мастер 3, 1-р зэргийн 142, 2-р зэргийн 59, 3-р зэргийн 36, нийт 237 цол зэрэгтэй тамирчин төрөн гарсан	100%	
16	Арга хэмжээ 2.4. Спортын төрлүүдээр амжилт гаргасан тамирчид,	Улсын төсөв	-Мөнгөн урамшуулад хамрагдсан тамирчид	12 тамирчин 3 дасгалжуулагчид 2.5 сая	Мөнгөн урамшуулалы н хэмжээг 2	Аймгийн ЗД-ын дэргэдэх өсвөрийн шишгээ багийн тамирчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор 2022.06.16-ны өдрийн А/37 тоот	100%	

	дасгалжуулагчдыг шагнаж урамшуулна.	10 000 0 сая төгрөг	дасгалжуулагчдын тоо	төгрөгийн мөнгөн урамгуулал олгосон	дахин нэмэгдүүлнэ	захирамжаар 15.2 сая төгрөг зарцуулах эрхийг орон нутгаас олгосон. Турк улсад зохион байгуулагдсан Ази тивийн аварга шалгаруулах дугуйн тэмцээнд оролцсон 2 тамирчинд 600.000 төгрөг, өсвөрийн шигшээ багийн тамирчдыг олон улс, улс, бүсийн тэмцээн уралдаанд оролцоход 15.020.000 сая төгрөгийн дэмжлэг тусалцааг 98 тамирчинд үзүүлсэн.		
17	Арга хэмжээ 2.5. Аймгийн үндэсний спортын VII их наадмыг зохион явуулж үндэсний спортын төрлүүдийн орчин нөхцөлийг сайжруулна	Орон нутгийн төсөв 10 000 0 сая төгрөг	Зохион байгуулсан арга хэмжээ Хамрагдсан хүний тоо	14 арга хэмжээнд 492 хүн	24 арга хэмжээнд 5200 хүн	Аймгийн үндэсний спортын VII их наадмыг мөсний сур, шагай, үндэсний сурын харвааны төрлүүдээр зохион явуулан 18 сумын 101 тамирчин хамрагдаж, үндэсний спортын VII их наадмын шигшээ тэмцээнд мөсний сурын харвааны тамирчид 2-р байр мөнгөн медаль хүртсэн. Үндэсний спортын VII их наадмын шигшээ тэмцээнд 63 тамирчинг оролцуулж 4 алт, 5 мөнгө, 5 хүрэл, нийт 14 медаль хүртэж спортын дэд мастер 2 шинээр төрөн гарсан. Аймгийн үндэсний спортын төрлөөр 13 арга хэмжээнд 2686 хүнийг хамруулж “Най уухай” теле нэвтрүүлэгийг аймгийн шагайн харвааны холбоотой хамтран явуулж 5 сумын 50 гаруй харваачдыг, хэрэглэл материалыг нэмэгдүүлж, орчин нөхцөлийг сайжруулахаар 12 сум шагайн харвааны, 6 сум сурын харвааны нум, хэрэглэл, 3 сум үндэсний бөхийн зодог шуудаг, БТСГазар мөсний шагайн харвааг хөгжүүлэхээр хасаа, сумыг авч хэрэглэл материалыг нэмэгдүүлнэ.	100%	

18	<p>Арга хэмжээ 2.6. Өсвөрийн шигшээ багийг спортын 13 төрлөөр хичээллүүлж амжилтыг ахиулна</p>	<p>Орон нутгийн төсөв 20 000 0 сая төгрөг</p>	<p>-Шигшээ багийн тоо -Тамирчдын тоо</p>	<p>6 төрлөөр 78 тамирчин хичээллэсэн</p>	<p>13 төрлөөр 170 тамирчинтай хичээллэнэ</p>	<p>Аймгийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийг спортын 13 төрлөөр 160 тамирчинтай хичээллүүлж улс, бүс, олон улс, тив, дэлхийн тэмцээнээс 181 алт, 178 мөнгө, 208 хүрэл нийт 567 медаль хүртэж спортын мастер 4, дэд мастер 2, нийт 218 тамирчин спортын цол зэрэг биелүүлсэн. Самбо бөхийн Чандмань-Оргил дэвжээний тамирчин Д.Номин сурагчдын 19-р олимпын наадмаас хүрэл медаль, Арабын нийслэл Абу Дубай хотноо болсон жюү-жицүгийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс алт, Б.Мишээл алт, Ч. Урангоо хүрэл, Ливан улсад зохиогдсон өсвөрийн самбо бөхийн Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнээс Чандмань-Оргил дэвжээний тамирчин Д.Номин мөнгө, Б.Арвин хүрэл медаль, Армен улсын Ереван хотод болсон самбо бөхийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Б.Батдаваа алт, ОХУ-д болсон Дети-Ази хүүхдийн спортын 7-р наадмаас мастристлингийн төрлөөр С.Заяа хүрэл, самбо бөхийн төрлөөр Б.Чинхүслэн хүрэл, Сурагчдын 19 олимпын наадамд, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд дугуй, чөлөөт бөх, масристинг, самбо бөх, жү-до бөх, жюү-жицү бөхийн төрлүүдээр оролцож 9 алт, 4 мөнгө, 8 хүрэл, нийт 21 медаль хүртлээ.</p>	100%	
19	<p>Арга хэмжээ 2.7. Монголын бүх ард түмний XV их наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, улсын</p>	<p>Улсын төсөв 5 000 0 сая төгрөг</p>	<p>Хамрагдсан иргэдийн тоо Улсын тэмцээнд</p>	-	<p>8 төрлөөр зохион явуулж 1200 иргэнийг хамруулна</p>	<p>Монголын бүх ард түмний XV их наадмыг аймгийн хэмжээнд спортын 12 төрлөөр зохион явуулж 2564 иргэнийг хамруулан шигшээ тэмцээнд 12 төрлөөр 158 тамирчин оролцуулж 1 алт, 2 мөнгө,</p>	100%	

	уралдаан тэмцээнд оролцох хамрагдах хүний тоог нэмэгдүүлнэ		оролцох төрлийн тоо		УАШТ-нд 5 төрлөөр оролцоно	5 хүрэл нийт 8 медаль хүртэн 18-р байранд шалгарсан.		
20	Арга хэмжээ 2.8. Биеийн тамир спортыг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөл бөмбөгийн “Залуучуудын шигшээ багийг” байгуулна.	Орон нутгийн төсөв 20 000 0 сая төгрөг	Шигшээ багийн тоо		Хөлбөмбөгийн н төрлөөр залуучуудын шигшээ багийг байгуулна.	Төр хувийн хэвшлийн түншлэл тулгуурлан спортын төрлүүдийг хөгжүүлэх бодлогын хүрээнд 22 холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулан хөл бөмбөгийн төрлөөр Залуучуудын шигшээ багийг Төв Ургац нэртэй байгуулан 21 аймгийн цомын төлөөх тэмцээнд мөнгөн медаль, насанд хүрэгчдийн “Төв-Азраганууд” баг монголын хөл бөмбөгийн лигийн тэмцээнд тэргүүн байрыг эзэлсэн.	100 %	
21	Арга хэмжээ 2.9. Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгуулан улсын аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдыг оролцуулах.	Улсын төсөв 10 000 0 сая төгрөг	-Спортын төрлийн тоо	5 УАШТ-нд 11 төрлөөр оролцсон	6 УАШТ-нд 20 төрлөөр оролцоно	Улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнийг цана, дугуй, таеквондо, үндэсний сур, байт харваа, граунд гольф, хөл бөмбөгийн төрлөөр зохион явуулж 918 тамирчинг хамруулж, Улс, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд спортын 23 төрлөөр 468 тамирчинг оролцуулж 636 медаль хүртэн 237 тамирчин спортын цол зэргийн болзол биелүүлээ.	100%	
22	Арга хэмжээ 2.10. Өвлийн спортын төрлүүдийг дүрэм, журмын дагуу хөгжүүлж хичээллэгчдийн тоог нэмэгдүүлнэ	Улсын төсөв 5 000 0 сая төгрөг	Спортын төрлийг хөгжүүлсэн сумдын тоо	3	5	Цана тэшүүрийн спортыг хөгжүүлэх түүгээр хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх өвлийн улиралд мөсөн талбай байгуулах ажлыг өрнүүлэн Алтанбулаг, Лүн, Эрдэнэ сумдад тэшүүрийн спортыг хөгжүүлэх, Жаргалант, Заамар, Борнуур, Архуст, Батсүмбэр сумдад цанын спортыг хөгжүүлэх бодлого баримтлан ажиллаж тус сумдад спортын хэрэглэл материалыг олгосон.Цанын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 4 сумын 48, тэшүүрийн тэмцээнд 3 сумын 52 тамирчин оролцсон.Цанын төвийн бүс,	100%	

						өсвөр үеийн УАШТ-ийг Борнуур суманд зохион явуулж багийн дүнгээр 1-р байр, тэшүүрийн өсвөр үеийн УАШТ-нд манай баг тамирчид тэргүүн байрыг эзлсэн.		
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Төсөв, санхүү, Хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдал, албан хаагчдын нийгмийн баталгааг ханган, сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулна.								
23	Зорилт 3.1. Байгууллагын хэмжээнд хэрэгжиж буй хууль, дүрэм, журам, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдал, хүний нөөцийг чадавхжуулах сургалтад хамруулан албан хаагчдын нийгмийн баталгааг хангана	Улсын төсөв 5 000 0 сая төгрөг	-Хууль тогтоомжийн хэрэгжилт -Хүний нөөцийг чадвахжуулалт -Нийгмийн баталгааг хангасан байдал	- Сар, улирал, хагас бүтэн жилээр тайлагнасан.	Үйл ажиллагааны гүйцэтгэлээр	Хууль, тогтоомж, бодлого хөтөлбөрийн хэрэгжилт, төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг ханган ажиллаж албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор багш дасгалжуулагчдын өрөө танхимын дулааны системд засвар үйлчилгээ хийж, хоолны хөнгөлөлтийг өдрийн 5.000 төгрөг, ур чадварын нэмэгдлийг улирал тутамд, мөнгөн урамшуулалыг хагас бүтэн жилээр олгож, цалинтай чөлөөг 12 албан хаагчид олгон, мэргэшүүлэх сургалтад 2, монгол хэл бичгийн чадварыг ахиулах сургалтад 12, албан хэргийн Монгол бичгээр хослуулах сургалтад бичиг хэргийн ажилтанг хамруулсан.	98.5%	
24	Арга хэмжээ 3.1.1. Биеийн тамир, спортын салбарт хэрэгжиж буй тогтоол шийдвэр, шинээр батлагдсан хөдөлмөрийн тухай хууль, холбогдох дүрэм журмуудын хэрэгжилтийн ханган ажиллана.	-	-Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц	Хууль тогтоомжийн хэрэгжилт 92.8 %-тай хэрэгжсэн	Хууль тогтоомжийг 100 % хэрэгжүүлсэн байна.	Биеийн тамир, спортын салбарт хэрэгжиж буй тогтоол шийдвэр болон шинээр батлагдсан хөдөлмөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхээр байгууллагын дотоод журмыг шинэчлэн боловсруулж байгууллагын дарга 2022.03.24-ны өдрийн А/28 тоот тушаалаар батлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж, бодлого хөтөлбөрийн хэрэгжилт ИТХ-ын тогтоолын хэрэгжилт 100%, ЗД-ын захирамжийн хэрэгжилт 98.89%, ЗД-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 99.86%, Хөгжлийн жилийн	100%	

						төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай хэрэгжлээ.		
25	Арга хэмжээ 3.1.2. Жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллаж, сургалт нөлөөллийн арга хэмжээнд албан хаагчдыг хамруулж ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх заалтуудыг дотоод журамд тусган мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	-		98.6 %-тай хэрэгжсэн	Хэрэгжилтийг 100% хангана	Аймгийн жендерийн эрх тэгш байдлыг хангах салбар хорооны нарийн бичгийн дарга Д.Лхагвасүрэнгээр жендерийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжуудын талаарх сургалтыг явуулан 14 албан хаагчийг хамруулсан. 2022 онд нийтийн биеийн тамир, их спортын 391 арга хэмжээнд 55218 иргэнийг хамруулахад 32082 эрэгтэй, 23136 эмэгтэй, спортын секц дугуйланг 21 төрлөөр хичээллүүлж 10351 хүүхэд залуучуудыг хамруулахад 13879 эрэгтэй, 10659 эмэгтэй байна. Жендерт суурлисан хүчирхийлэлтэй тэмцэх “Нандин бүхнээ хамгаалъя-Өөрийгөө гэр бүлээ, орчин тойрноо” 16 хоногийн аянд нэгдэн албан хаагчид, спортын төрлийн секц дугуйлангийн сурагчид, тамирчдад жендерийн эрх тэгш байдлыг сурталчлан ажилласан. Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт сэдэвт 2 өдрийн сургалтад байгууллагын дарга 2022.06.27-28-ны өдрүүдэд хамрагдсан.	100 %	
26	Арга хэмжээ 3.1.3. Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангаж иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэн, монгол бичгээр албан хэрэг хөтлөх программ ашиглах, цахим бичвэр бичих сургалтад бичиг	Улсын төсөв 1.5 сая төгрөг	Шийдвэрлэсэн өргөдөл гомдлын тоо	2 өргөдөл 4 хүсэлт	Монгол бичгийн программ суулгасан байна.	2022 онд байгууллагад иргэд, албан хаагчдаас 19 санал хүсэлт ирүүлсэнийг хугацаанд нь шийдвэрлэсэн.БШУГ-аас зохион байгуулсан албан хэргийг Монгол бичгээр хослуулан явуулах сургалтад архив, бичиг хэргийн ажилтныг хамруулсан.2025 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн албан хэргийг хөтлөх бэлтгэл ханган монгол бичгийн бичвэрийн программыг 6 албан хаагчийн компьютерт суулган бичих дадлагыг хийн ажиллаж байна.Аймгийн албан бус боловсролын	100%	

	хэргийн ажилтныг сурган, крилл монгол бичгийг хослуулан хөтлөж эхэлнэ					төвтэй хамтарсан монгол бичгийн сургалтад 12 албан хаагчийг хамруулсан.		
27	Арга хэмжээ 3.1.4. Байгууллагын болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын ажлын хавтас, нэрийн хуудас, мандат зэргийг монгол бичгээр бичиж, Хүмүүн бичиг, сонинг захиалах, алба хэргийг монгол бичгээр хөтлөх сургалтад албан хаагчдыг хамруулах	-	Сонин захиалсан болон сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	12 хүн анхан шатны сурталтад хамрагдсан	15 хүнийг сонин сэтгүүл захиалуулж 19 хүнийг сургалтад хамруулна	Байгууллагын болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын ажлын хавтас, нэрийн хуудас, мандат зэргийг монгол бичгээр бичиж албан хэргийг монгол бичгээр хөтлөх сургалтад 12 албан хаагчдыг, архив бичиг хэргийн эрхлэгч Д.Энхцэцэгийг Аймгийн албан бус боловсролын төвөөс бичиг хэргийн эрхлэгч нарын дунд зохиогдсон Монгол бичгийн сургалт компьютерийн бичвэрийн программд сургах 45 хоногийн сургалтад хамруулсан.	100%	
28	Арга хэмжээ 3.1.5. Байгууллагын хэмжээнд хүүхэд хамгаалал, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	-	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Албан хаагчдын гэр бүл, үр хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс байгууллагын нийт албан хаагчдын 23 хүүхдийг улирлын амралтын үеэр олон улсын циркийн тоглолт, эх үрсийн баяр, хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 30 хүүхдэд 900.000 мянган төгрөгийн гарын бэлэг олгосон.Уралдаан тэмцээнд оролцож байгаа хүүхдүүдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар техникийн зөвлөгөөн дээр хариуцсан багш нарт нь тогтмол хэлж сануулсаны үр дүнд гэмт хэрэг зөрчилд холбогдсон тамирчид байхгүй байна.Байгууллагын ёс зүйн зөвлөл болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зөвлөлийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай хэрэгжсэн.	100%	

29	Арга хэмжээ 3.1.6. Төсөв санхүүг зориулалтын дагуу өр авлага үүсгэхгүй зарцуулж мэдээ тайланг цаг хугацаанд нь өгч шилэн дансны хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсөв, гүйцэтгэлийг ил тодоор цахим сүлжээнд байрлуулан хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж баталгаажуулна.	-	Төсвийг зориулалтын дагуу өр авлага үүсгэхгүй төсөв, гүйцэтгэлийг ил тодоор тайлагнах	751.7 сая төгрөг зарцуусан	Үйл ажиллагааны гүйцэтгэлээр	2022 онд өөрийн орлогоор 10.0 сая төгрөг оруулж зарцуулах төлөвлөгөө батлуулснаас оны эхний 05-р сарын байдлаар 14.3 сая төгрөгийн орлого оруулснаас 1,5 сая төгрөгийг цалин, НДШ-д, урсгал засвар, гадна тохижилтын ажилд 7.1 сая төгрөгийг зарцуулж 5.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.	100 %	
30	Арга хэмжээ 3.1.7. БТСГ-ын спорт заалны шалыг засварлан стандарт хангуулна	Орон нутгийн төсөв 283.0 сая төгрөг	Зарцуулсан зардал	-	Спорт заалны шал засварлагдсан байна.	БТСГ-ын спортын ордны шалыг засварлахаар 283 сая төгрөгийг 2022 оны төсөвт тусган батлуулсанаар засварын ажлын тендерийн нээлттэй сонгон шалгаруулалтаар “DALT-XXK” шалгаран засварын ажил 2022.12.05-нд эхлэн хийгдэж байна.	100%	
31	Арга хэмжээ 3.1.8. Албан хаагчдад ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэн авлига ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтад хамруулна.		Сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо	1 сургалт 6 хүн	3-4 сургалтад 10-18 хүнийг хамруулна.	Авлигын эсрэг хамтдаа- таны эрх, таны оролцоо сэдэвт аяныг 2022 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс 8 өдрүүдэд амжилттай зохион байгуулж аяны хүрээнд Зөв хандлага-Эерэг нөлөө сургалт нөлөөллийн аянд байгууллагын 20 албан хаагчдыг хамрууллаа. Аяны хүрээнд авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн эрхэмлэх эрх, үүрэг зэрэг сэдвүүдээр нээлттэй ярилцлага өрнүүллээ. Байгууллагын цахим хуудас болон вэб сайтаар авлигалын эсрэг мэдээ	100%	

						мэдээллийг цаг тухай бүрт нийтэлж ажиллалаа. “Таны эрх, таны оролцоо-авлигад үгүй гэж хэлье” соён гэгээрүүлэх өдөрлөгт байгууллагын албан хаагчдыг хамруулсан.		
32	Арга хэмжээ 3.1.9. Байгууллагын дотоод аудитын үйл ажиллагааг идэвхжүүлэн хяналт шинжилгээ хийх, үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулна.		-Хяналт шалгалт хийгдсэн тоо -Гарсан зөрчил дутагдлын тоо	1 удаагийн шалгалтаар 2 зөрчил илрүүлж арилгуулсан	Үйл ажиллагааны гүйцэтгэлээр	Байгууллагын дотоод аудитын 2022 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу байгууллагын шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, уралдаан тэмцээний мандат хураасан байдал, өөрийн орлогын төлөвлөгөөний биелэлт, зааланд цаг өгөх байдал, хяналтын картаар хариуцсан бодлого хөтөлбөрийн хэрэгжилт зэрэгт 4 удаагийн хяналт шалгалтыг явуулж илэрсэн зөрчил дутагдал хяналт тавьж хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажилласан.Хугацаатай үүрэг даалгавар, төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай хэрэгжсэн.	100%	
33	Арга хэмжээ 3.1.10. Албан хаагчдын нийгмийн баталгаа хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулах, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна	-	Нийгмийн баталгаа хангагдсан албан хаагчдын тоо	5 албан хаагч урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдан 3 албан хаагчид 500.000 төгрөгийн тусламж олгосон	Үйл ажиллагааны гүйцэтгэлээр	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийг бэхжүүлэх зорилгоор эрт илрүүлэг, оншилгоонд хамруулахаар албан хаагчдын судалгааг гарган ЭМГ-т хүргүүлснээр 2022.06.27-28-ны өдрүүдэд 18-30 нас эр 2, эм 2, 31-45 нас эр 5, эм 1, 46-60 нас эр 4, эм 5, 60-аас дээш нас эм 1 нийт 20 албан хаагчийг хамруулсан.Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор багш дасгалжуулагчдын өрөөг засварлан дулааны шугам сүлжээг янзлан нэмэгдүүлсэн	100 %	
34	Арга хэмжээ 3.1.11. Аймаг байгуулагдсаны 100-н жил, БТС-ын байгууллагын 70-н жилийн ойг угтсан	Үйл ажиллагааны орлого	Хийгдсэн ажил, зарцуулсан хөрөнгийн хэмжээ	-	Бүтээн байгуулалтын 3-5 ажлыг хийж гүйцэтгэнэ	Аймаг байгуулагдсаны 100, Зуунмод сум үүсгэн байгуулагдсаны 80-н жилийн ойг угтсан бүтээлч ажлын төлөвлөгөөний дагуу байгууллага орчноо тохижуулах, бүтээн		

	бүтээлч ажлуудыг үе шаттай хийж байгууллагын гадна талд урсдаг самбар бүхий цагийг байрлуулна.	2,5 сая төгрөг				байгуулалтын ажлын талаар, сар, улирлын төлөвлөгөөнд тусган ажиллаж төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай хэрэгжсэн. Байгууллагын гадна тохижилт, болон электрон цагийг байрлуулах ажилд 7.5 сая төгрөгийг зарцуулж цагийг суулгасан.	100%	
35	Арга хэмжээ 3.1.12. Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд байгууллагын өөрийн эзэмшлийн талбайд 300 ширхэг, нийтийн эзэмшлийн талбайд 500 ширхэг мод бут суулган ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ	Үйл ажиллагааны орлого	Ширээн суулгасан мод буины тоо	300 ширхэг мод бут суулгасан	Өөрийн эзэмшлийн талбайд 300 нийтийн эзэмшлийн талбайд 500 ширхэг суулгацыг суулгана	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд байгууллагын хашаанд навчит шар хуайс 412 ширхэг, цэцгийн мандалд 2000 цэцгийн үрийг шинээр суулган аймгийн төв сад болон нийтийн эзэмшлийн талбайд 70 м газарт мод тарих нүх ухаж, шар хуайс 100 ширхэгийг суулгасан. Бүх нийтээр мод тарих өдрөөр нийтийн эзэмшлийн талбай болон одонт хөтөл дэх цэцэрлэгт хүрээлэнд 30 ширхэг шар хуайсыг шинээр суулгасан	100%	
36	Арга хэмжээ 3.1.13. Төрийн үйлчилгээний албан хаагчдын нийгмийн баталгааг хангах боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор тэднийг төрийн жинхэнэ албан хаагчид болгох сургалт, шалгалтад хамруулан зэрэг дэвийг ахиулна.	-	Төрийн албаны шалгалт өгч тэнцсэн албан хаагчдын тоо	-	ТАШ 10 албан хаагчдыг хамаруулна.	2022.04.01.02-нд зохион байгуулагдсан төрийн албаны ерөнхий шалгалтад 5 албан хаагч бүртгүүлэн шалгалтад орж 1 албан хаагч ерөнхий шалгалтад тэнцэж төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн.	70%	
37	Арга хэмжээ 3.1.14. Спортын төрөлжсөн сургалттай сургуулийн сургалтын хөтөлбөрийг БШУГ-тай хамтран боловсруулан, багшлах боловсон хүчнийг	-	Хичээллэгчдийн тоо Багш дасгалжуулагчдын тоо		640 хүүхэд 20-30 багш сонгон шалгаруулаж үйл ажиллагааг эхлүүлсэн байна.	640 хүүхдийн төрөлжсөн сургалттай дунд сургуулийн барилгын ажлын гүйцэтгэл 89%-тай хийгдэж төсөв санхүүгийн байдлаас шалтгаалан 2022 онд ашиглалтад орох боломжгүй болсон боловч багшлах боловсон хүчний судалгаа шаардлагатай тоног	70%	

	сонгон шалгаруулж сургалтыг эхлүүлнэ.					төхөөрөмж, хэрэглэл материалын судалгааг гарган БШУГ-т хүргүүлсэн.		
38	Арга хэмжээ 3.1.15. Архивын баримтад тооллого явуулах ажлыг зохион байгуулна.	-	Баримтын тооллого хийснээр		Архивын баримтын тооллогыг хийж дүн гарсан байна.	Байгууллагын архивын баримтад тооллого хийх тухай А/134 дугаар захирамжийг үндэслэн байгууллагын даргын 2022.03.31-ны өдрийн А/31 тоот тушаалаар тооллого явуулах ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж 2022.04.04-11-ны өдрүүдэд багтаан тооллогыг зохион явуулсан. Байгууллагын архивт хадгалагдаж буй 70 жил хадгалах 3 хайрцаг бүхий 34 ширхэг хадгаламжийн нэгж 9.9 кг, байнга хадгалах 10 хайрцаг бүхий 63 хадгаламжийн нэгж 39.7 кг, түр хадгалах 46 хайрцаг бүхий 217 хадгаламжийн нэгж 173.8 кг, нийт 59 хайрцаг, 314 ширхэг 223.4 кг бүхий хадгаламжийн нэгжүүдийг данс бүртгэлтэй тулган, баримт нэг бүрийн шинж чанарыг шалгаж тоолсон.	100%	
39	Арга хэмжээ 3.1.16. “Байгууллагын архивын нийтлэг журам”-ын дагуу архивын баримтыг зориулалтын байр, тавиур шүүгээнд хадгалах нөхцөлөөр хангана.	Үйл ажиллагааны орлого	Стандартад ойртуулсанаар		Архивын баримтын хадгалалт хамгаалалтын нөхцөл сайжирсан байна	Архивын баримт бичгийг зориулалтын тавиур шүүгээнд хадгалах зорилгоор архивын өрөөтэй болж 3 давхар төмөр тавиур болон төмөр шүүгээтэй болгосон.	100%	
40	Арга хэмжээ 3.1.17. Байгууллагын үйл ажиллагааг орон нутгийн үйл ажиллагаатай уялдуулах нутгийн захиргааны байгууллага нэгжтэй харилцан хамтран ажиллах	-	Үйл ажиллагааны үр дүнгээр	Нэгдсэн шуурхайн хуралд 24 удаа, аймгийн ЗД-ын зөвлөлийн хурлаар 1	Нэгдсэн болон хэлтсийн шуурхай, ЗД-ын зөвлөлийн хуралд оролцоно	Байгууллагын үйл ажиллагааг орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах зорилгоор нийгмийн бодлогын харьяа байгууллагуудтай хамтран 8 суманд нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж аймгийн ЗДТГ-ын ХШҮДОХ-ийн мэргэжилтэн Д.Бадамсүрэн, 2021 оны 374-р тогтоол,	100%	

				асуудлыг хэлэлцүүлсэн		аймгийн ЗД-ын 2022 оны А/300-р захирамжаар бодлогын баримт бичигт хяналт шинжилгээ хийх аргачлал, дүрэм журам, Жендрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн талаар аймгийн ЖЭТБХ аймгийн салбар хорооны нарийн бичиг Д.Лхагвасүрэн нартай хамтран сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 14 албан хаагчийг хамруулсан.		
НИЙТ 3 ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД 37 ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭН 96.4%-ТАЙ ХЭРЭГЖСЭН.								

--oOo--